



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/163

Есөнбулаг сум

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
хаврын дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.4, 9.5, 9.6 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/59 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2026 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах үхэр, гахайн тоо, шаардагдах вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Дархлаажуулалтын арга хэмжээнд шаардагдах вакцин биобэлдмэлийг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэст (Д.Чинзориг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 25-ны өдрийн А/дүгээр  
захирамжийн хавсралт/163

ШҮЛХИЙН ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ  
МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

Сумын нэр	Хаврын дархлаажуулалтад хамрагдах малын тоо			Шүлхийн вакцин
	Үхэр	Гахай	Нийт мал, амьтан	Олгосон тун
Алтай	1,481		1,481	1,500
Баян-Уул	6,912		6,912	6,900
Бигэр	6,946		6,946	6,950
Бугат	2,026		2,026	2,000
Дарив	4,875		4,875	4,875
Дэлгэр	5,277	12	5,289	5,250
Жаргалан	7,576	2	7,578	7,550
Тайшир	3,131		3,131	3,100
Тонхил	2,908		2,908	2,900
Төгрөг	2,856	17	2,873	2,900
Халиун	6,368		6,368	6,400
Хөхморьт	8,053		8,053	8,050
Цогт	4,748		4,748	4,750
Цээл	3,321		3,321	3,350
Чандмань	3,964		3,964	4,000
Шарга	6,301		6,301	6,300
Эрдэнэ	1,988		1,988	2,000
Есөнбулаг	3702	70	3,772	3,800
Нийт	82433	101	82534	82875

\_ оОо \_



מחולק

מס' 190716008

התביעה המחוזית תל אביב (מ.ב.ת.ת.ת.) בענין המעוררים \* \* \*

1. \* \* \* המעוררים \* \* \* (מ.ב.ת.ת.ת.) בענין המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

המעוררים \* \* \*

המעוררים \* \* \* המעוררים \* \* \* המעוררים \* \* \*

מס' 190716008

מס' 190716008



משרד המשפטים - תל אביב  
מס' 190716008